



## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 4/04

Улаанбаатар хот

Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэлийн татварын газар, дүүргийн татварын хэлтсийн орон тоог шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Сангийн сайдын 2023 оны 271 дүгээр тушаал, Татварын ерөнхий газрын даргын 2024 оны А/03 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэлийн татварын газар, дүүргийн татварын хэлтсийн орон тоог хавсралт ёсоор шинэчлэн баталж, 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг харьяа нэгж, аймаг, нийслэлийн татварын газар, дүүргийн татварын хэлтсийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

3. Орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан шаардах хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд хуваарилахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Бямбадорж)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын 2023 оны А/36, А/212, А/217 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ЧИМИДСҮРЭН

152312857



Татварын ерөнхий газрын даргын  
2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн  
А/04 дүгээр тушаалын хавсралт

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА НЭГЖ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТАТВАРЫН ГАЗАР,  
ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
<b>26</b>	<b>Нийслэлийн татварын газар</b>		<b>77</b>
	Дарга	ТЗ-3	1
<b>26.1</b>	<b>Захиргааны хэлтэс</b>		<b>11</b>
26.1.1	Хэлтсийн дарга	ТЗ-4	1
26.1.2	Захиргааны асуудал хариуцсан татварын улсын байцаагч	ТЗ-7	1
26.1.3	Дотоод ажил өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн	ТЗ-7	1
26.1.4	Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-7	1
26.1.5	Нягтлан бодогч	ТЗ-7	1
26.1.6	Аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-7	1
26.1.7	Сүлжээний мэргэжилтэн	ТҮ-7	1
26.1.8	Архив-бичиг хэргийн эрхлэгч	ТҮ-5	1
26.1.9	Даргын туслах	ТҮ-4	1
26.1.10	Нярав	ТҮ-4	1
26.1.11	Жолооч	ТҮ-3	1
<b>26.2</b>	<b>Хуулийн хэлтэс</b>		<b>8</b>
26.2.1	Хэлтсийн дарга	ТЗ-4	1
26.2.2	Татварын улсын байцаагч	ТЗ-7	5
26.2.3	МТЗ-ийн магадлагч татварын улсын байцаагч	ТЗ-7	1
26.2.4	МТЗ-ийн магадлагч-нарийн бичгийн дарга ТУБ	ТЗ-7	1
<b>26.3</b>	<b>Дунд татвар төлөгчтэй харилцах хэлтэс</b>		<b>22</b>
26.3.1	Хэлтсийн дарга	ТЗ-4	1
26.3.2	Татварын улсын байцаагч	ТЗ-7	19
26.3.3	Орлогын бүртгэл, хяналт хариуцсан татварын улсын байцаагч	ТЗ-7	2
<b>26.4</b>	<b>Төсвийн орлого, удирдлагын хэлтэс</b>		<b>10</b>
26.4.1	Хэлтсийн дарга	ТЗ-4	1
26.4.2	Татварын улсын байцаагч	ТЗ-7	8
26.4.3	Орлогын бүртгэл, хяналт хариуцсан татварын улсын байцаагч	ТЗ-7	1
<b>26.5</b>	<b>Татварын хяналт, шалгалтын хэлтэс</b>		<b>25</b>
26.5.1	Хэлтсийн дарга	ТЗ-4	1
26.5.2	Татварын улсын байцаагч	ТЗ-7	24

....оОо....